



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Т.Одсүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	14
3.5.2 Авлага	14
3.5.3 Бараа материал.....	15
3.5.4 Үндсэн хөрөнгө	17
3.5.5 Өр төлбөр	18
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	19
3.5.7 Орлогын данс	19
3.5.8 Зардлын данс	20
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	21
3.6.1 Төсвийн төлөвлөлт	23
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	24
3.6.3 Нэмэлт төсөв	25
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	26
3.8 Аудитын гол асуудал.....	26
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	26
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	27
3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт	27
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	27
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	28
4. Аудитын илрүүлэлт	29
4.1 Залруулсан алдаа	29
4.2 Төлбөрийн акт	30
4.3 Албан шаардлага	31
4.4 Зөвлөмж.....	32
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	34-36

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ББН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам тээвэр хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХАА	Хөдөө аж ахуй
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БАТ-ОРХОН ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № *СА-2022/08-НА-СТА-ТТЗ*

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp of the State Audit Agency of Mongolia is centered. It contains the Mongolian text "МОНГОЛЫН ДӨНДӨР АУДИТЫН АГЫН ГЭРЭГ" (State Audit Agency of Mongolia) and "УЛСЫН АУДИТЫН АГЫН ГЭРЭГ" (National Audit Agency). A handwritten signature in black ink is written over the stamp.

Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	505,992.70	1,076,877.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	83,242.70	662,150.80
33	АВЛАГА	200,973.50	162,025.30
35	БАРАА МАТЕРИАЛ	221,776.40	252,701.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,990,759.60	4,669,819.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,990,759.60	4,669,819.30
39200	Биет хөрөнгө	3,920,532.00	4,600,339.20
39300	Биет бус хөрөнгө	70,227.60	69,480.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,496,752.30	5,746,697.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,650.70	61,169.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,650.70	61,169.10
41300	Өглөг	1,650.70	61,169.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,495,101.60	5,685,528.00
51	Засгийн газрын хувь оролцоо	4,495,101.60	5,685,528.00
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	906,101.30	906,101.30
51200	Хуримтлагдсан үр дүн	2,940,651.10	4,131,077.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	648,349.20	648,349.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,496,752.30	5,746,697.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,521,022.70	3,669,468.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	75,734.40	186,740.30
110	Орлогын албан татвар	54,393.40	34,547.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	54,393.40	34,547.80
113	Хөрөнгийн албан татвар	1,514.00	92,822.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	19,827.00	59,370.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,848,294.00	1,373,585.80
120	Нийтлэг татварын бус орлого	1,848,294.00	1,373,585.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,596,994.20	2,109,142.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,790,025.80	2,300,455.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,790,025.80	2,300,455.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,975,530.10	2,198,222.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,097,177.10	1,173,130.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,270.40	151,802.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	292,235.90	333,773.40
2104	Хангамж, бараа материалын зардал	66,930.70	80,392.70
2105	Нормативт зардал	87,869.50	143,461.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,014.60	23,160.00
2107	Томилолт, зочны зардал	2,925.50	2,987.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,700.10	18,503.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	251,406.40	271,010.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	814,495.60	102,232.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,730,996.90	1,369,013.20

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	100,394.20	178,586.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,630,602.80	1,190,426.30

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,864,498.90	-	2,864,498.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,864,498.90	-	2,864,498.90
9	Тайлант үеийн үр дүн	1,630,602.80	-	1,630,602.80
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,495,101.60	-	4,495,101.60
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,495,101.60	-	4,495,101.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,495,101.60	-	4,495,101.60
19	Тайлант үеийн үр дүн	1,190,426.30	-	1,190,426.30
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,685,528.00	-	5,685,528.00

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,781,762.60	2,822,206.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	75,734.40	186,740.30
110	Орлогын албан татвар	54,393.40	34,547.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	54,393.40	34,547.80
113	Хөрөнгийн албан татвар	1,514.00	92,822.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	19,827.00	59,370.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,545.10	6,701.50
1181	Газрын төлбөр	11,407.90	28,596.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,874.00	24,072.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,416.40	546,193.50
120	Нийтлэг татварын бус орлого	107,416.40	546,193.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,598,611.70	2,089,272.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,597,694.60	2,001,128.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,597,694.60	2,001,128.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,782,284.00	1,893,031.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,098,386.70	1,167,925.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,461.40	151,089.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	292,658.80	282,129.20
2104	Хангамж, бараа материалын зардал	55,438.20	68,865.70
2105	Нормативт зардал	95,651.80	133,969.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,118.40	29,943.90
2107	Томилолт, зочны зардал	2,925.50	2,987.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,532.10	28,784.40

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,111.20	27,337.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	815,410.60	108,096.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	184,067.90	821,077.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	130,268.80	153,169.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	130,268.80	153,169.60
2200	Дотоод эх үүсвэрээр	130,268.80	153,169.60
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(130,268.80)	(153,169.60)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(50,000.00)	(89,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000.00	89,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,799.20	578,908.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	79,443.60	83,242.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83,242.70	662,150.80

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт/ хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,153,863.70	1,999,196.06	154,667.64	92.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,907,558.70	1,805,056.66	102,502.04	94.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,880,642.10	1,780,242.13	100,399.97	94.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,188,593.00	1,141,988.55	46,604.45	96.08
210101	Үндсэн цалин	838,024.30	803,978.89	34,045.41	95.94
210102	Нэмэгдэл	273,106.30	257,787.48	15,318.82	94.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,731.00	3,755.00	976.00	79.37
210104	Урамшуулал	57,756.20	68,643.30	(10,887.10)	118.85
210105	Гэрээт ажлын хөлс	14,975.20	7,823.88	7,151.32	52.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,521.20	147,803.88	14,717.32	90.94
210201	Тэтгэврийн даатгал	113,701.60	102,831.87	10,869.73	90.44
210202	Тэтгэмжийн даатгал	12,206.70	11,569.77	636.93	94.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,749.40	9,317.98	431.42	95.57
210204	Ажилгүйдлийн даатгал	2,442.10	2,195.47	246.63	89.90
210205	Эрүүл мэндийн даатгал	24,421.40	21,888.78	2,532.62	89.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	286,162.10	280,638.19	5,523.91	98.07
210301	Гэрэл, цахилгаан	19,525.80	14,883.08	4,642.72	76.22
210302	Түлш, халаалт	265,492.30	264,611.11	881.19	99.67
210303	Цэвэр, бохир ус	1,144.00	1,144.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,270.50	60,485.00	2,785.50	95.60
210401	Бичиг хэрэг	5,123.40	5,744.79	(621.39)	112.13
210402	Тээвэр, шатахуун	36,550.10	35,647.27	902.83	97.53
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,480.30	6,272.54	207.76	96.79
210404	Ном, хэвлэл	280.80	280.80	-	100.00

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,761.70	3,170.60	2,591.10	55.03
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,074.20	9,369.00	(294.80)	103.25
2105	Нормативт зардал	81,226.10	66,711.67	14,514.43	82.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,522.30	22,522.30	-	100.00
210502	Хоол, хүнс	49,775.60	36,539.57	13,236.03	73.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,928.20	7,649.80	1,278.40	85.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,241.20	39,793.70	1,447.50	96.49
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,661.60	18,261.80	1,399.80	92.88
210602	Тавилга	5,000.00	5,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,145.40	2,145.40	-	100.00
210604	Урсгал засвар	14,434.20	14,386.50	47.70	99.67
2107	Томилолт, зочны зардал	3,396.50	2,807.60	588.90	82.66
210702	Дотоод албан томилолт	3,396.50	2,807.60	588.90	82.66
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,658.10	13,750.60	8,907.50	60.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,665.50	9,646.70	8,018.80	54.61
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,918.00	1,296.00	622.00	67.57
210803	Даатгалын үйлчилгээ	241.30	118.80	122.50	49.23
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,596.80	2,576.30	20.50	99.21
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	71.00	67.10	3.90	94.51
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	125.90	45.00	80.90	35.74
210807	Газрын төлбөр	0.70	0.70	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	38.90	-	38.90	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,573.40	26,262.95	5,310.45	83.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,573.70	22,279.05	5,294.65	80.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,999.70	3,983.90	15.80	99.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,916.60	24,814.53	2,102.07	92.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,916.60	24,814.53	2,102.07	92.19
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,935.70	11,909.12	2,026.58	85.46
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,980.90	12,905.41	75.49	99.42
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	157,139.40	105,139.40	52,000.00	66.91
220001	Барилга байгууламж	117,139.40	77,139.40	40,000.00	65.85
221001	Их засвар	7,000.00	-	7,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	33,000.00	28,000.00	5,000.00	84.85
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	89,165.60	89,000.00	165.60	99.81
230001	Эргэж төлөгдөх зээл	89,165.60	89,000.00	165.60	99.81
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,153,863.70	2,051,013.51	102,850.19	95.22

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,130,133.50	1,076,354.23	53,779.27	95.24
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,130,133.50	1,076,354.23	53,779.27	95.24
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	909,290.10	822,292.17	86,997.93	90.43
320001	Орон нутгийн төсвөөс	812,150.70	725,152.77	86,997.93	89.29
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	97,139.40	97,139.40	-	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,025.50	10,336.26	13,689.24	43.02
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,025.50	10,336.26	13,689.24	43.02
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	90,414.60	142,030.85	(51,616.25)	157.09
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,414.60	142,030.85	(51,616.25)	157.09
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	62,886.39	(62,886.39)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	114,703.84	(114,703.84)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	576.00	4,631.00	0.00	4,631.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	0.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	0.00	6.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	104.00	101.00	0.00	101.00
620001	Удирдах ажилтан	13.00	13.00	0.00	13.00
620002	Гүйцэтгэх ажилтан	56.00	54.00	0.00	54.00
620003	Үйлчлэх ажилтан	31.00	31.00	0.00	31.00
620004	Гэрээт ажилтан	4.00	3.00	0.00	3.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	362.00	362.00	0.00	362.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	268.00	268.00	0.00	268.00
630001	Төрийн өмчит ЕБС	268.00	268.00	0.00	268.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	94.00	94.00	0.00	94.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	94.00	94.00	0.00	94.00

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	196,513.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	196,513.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,819.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,936.57
210101	Үндсэн цалин	413.99
210102	Нэмэгдэл	25,522.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,285.52
210201	Тэтгэврийн даатгал	2,262.10
210202	Тэтгэмжийн даатгал	255.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	204.68

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	51.17
210205	Эрүүл мэндийн даатгал	511.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,490.98
210301	Гэрэл, цахилгаан	1,490.98
2104	Хангамж, бараа материалын зардал	8,556.32
210401	Бичиг хэрэг	1,078.01
210402	Тээвэр, шатахуун	5,770.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,214.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	471.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22.50
2105	Нормативт зардал	67,257.68
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	67,167.68
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	90.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,781.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,148.00
210602	Тавилга	1,725.00
210604	Урсгал засвар	1,908.00
2107	Томилолт, зочны зардал	180.00
210702	Дотоод албан томилолт	180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,033.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,033.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,298.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,298.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,693.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,800.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,893.27
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	11,893.27
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	196,513.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	196,513.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,509.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	107,092.59
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	69,911.16

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Орхон сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан, төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэсний үндсэн дээр сар бүр ур чадварын нэмэгдэл олгож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 3/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг дараах дөрвөн бодлогын хүрээнд тодорхойлсон байна. Үүнд:

- Засаглалын бодлого: Чадварлаг, ухаалаг хүртээмжтэй, нээлттэй засаглалын тогтолцоог бэхжүүлнэ
- Эдийн засгийн бодлого: Татварын бааз суурийг өргөтгөх, төсөв бүрдүүлэх, оновчтой зарцуулах, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, бүртгэл тооцооны ажилтны сахилга хариуцлагыг өндөржүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэн төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах,
- Хүнс, худалдаа, ХАА, байгаль орчны бодлого: Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж эрүүл аюулгүй хүнсний хангамжийг сайжруулна, ”
- Хүний хөгжлийн бодлого: Үндэсний эх хэл, соёл түүх, уламжлалаа дээдлэн байгальтай зөв харьцах чадварт суурилж, эх орноо хайрлах нэгдмэл санаатай монгол хүнийг соён гэгээрүүлнэ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Аймгийн “Чанарыг эрхэмлэх жил”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах, үр дүнг тооцох,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,
- Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.
- Төрийн үйлчилгээнд ухаалаг тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 1 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- 2 Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- 3 Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- 4 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- 5 УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон

- үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- 6 Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан
 - 7 Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
 - 8 Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
 - 9 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
 - 10 Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
 - 11 Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
 - 12 Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт

Орхон сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант жилийн хугацаанд аймгийн СТХС-ээс дотоод хяналтын төлөвлөгөө, удирдамжийн хүрээнд төрийн сангийн 1-9 дүгээр сарын үйл ажиллагааг хамруулан шалгаж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах 14 зөвлөмж өгч, хэрэгжилтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан тооцохоор болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,890,419.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 57,808.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 46,246.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 83,242.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 662,150.8 мянган төгрөг болж, 578,908.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	83,242.7	662,150.8	578,908.1
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж			
Дүн	83,242.7	662,150.8	578,908.1

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан орон нутгийн ерөнхий орлогын дансанд 547,447.0 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 1,000.0 мянган төгрөг, СХС-ийн дансанд 113,703.8 мянган төгрөг, нийт 662,150.8 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 200,973.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 162,025.3 мянган төгрөг болж, 38,948.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төлбөртэй үйлчилгээний авлага		11499.6	11,499.6
Зээлийн хүүгийн авлага	13,499.0	6,276.2	(7,222.8)
Байгууллагаас авах авлага	419.3	27.4	(391.9)
Хувь хүнээс авах авлага	1,158.2	1,789.0	630.8
Зээлийн авлага	185,897.0	142,433.2	(43,463.8)
Дүн	200,973.5	162,025.3	(38,948.3)

Эх сурвалж Орхон сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төлбөрт үйлчилгээний авлага 11,499.6 мянган төгрөгөөр өссөн нь коронавирусын халдвараар хөнгөн хэлбэрээр өвчилж, гэрээр эмчлэгдэх үед олгосон эмийн багцын санхүүжилт ЭМДЕГ-аас дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

Байгууллагаас авах авлагад бүртгэлтэй сургууль, цэцэрлэгийн 419.3 мянган төгрөгийн авлагыг тайлант онд бүрэн барагдуулсан боловч соёлын төв нь НДШ-д 27.4 мянган төгрөгийг илүү шилжүүлснээс авлага үүсгэсэн байна.

Хувь хүнээс авах дансны үлдэгдэл тайлант онд 630.8 мянган төгрөгөөр өссөн нь ЭМТ-ийн эмийн сангаас хувь хүмүүст зээлээр борлуулсан эмийн оны эхний авлагыг тайлант онд барагдуулсан боловч нэмж 1,789.0 мянган төгрөгийн эмийг зээлээр борлуулж барагдуулах арга хэмжээ аваагүйтэй холбоотойгоор өссөн байна

СХС-ийн зээлийн авлагын үлдэгдэл тайлант онд 43,463.8 мянган төгрөг, зээлийн хүүгийн авлага 7,222.8 мянган төгрөгөөр буурсан нь 2013-2018 онуудад олгосон хугацаа хэтэрсэн насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээг сайн авч хэрэгжүүлснээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ:

➤ Санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ-ын 1,549.1 мянган төгрөг, ЭМТ-ийн 4,183.8 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын тооцооны өмнөх оны устгах бичилтийг хийгээгүй.

ЗДТГ:

➤ Хэрэгжээгүй ажлын санхүүжилт / буцааж авах / 9,641.1 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн боловч санхүүжилтийн авлагаар бүртгээгүй.

ЭМТ:

➤ Тайлант онд эмийн сангаас хувь хүмүүст зээлээр борлуулалт хийж барагдуулаагүйгээс 1,789.0 мянган төгрөгийн авлага, үүсгэсэн.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 221,776.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 252,701.8 мянган төгрөг болж, 30,925.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	---------------------------

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тусгай зориулалттай материал	9,972.9	14,932.9	4,960.1
Эм боох материал	21,446.8	18,941.9	(2,504.9)
Бичиг хэргийн материал	16,315.9	18,947.9	2,632.0
Аж ахуйн материал	132,354.8	130,005.5	(2,349.3)
Сэлбэг хэрэгсэл	440.6	123.6	(317.0)
Түлш, шатах тослох материал	340.6	159.0	(181.6)
Барилгын засварын материал	3,137.6	-	(3,137.6)
Хүнсний материал	1,186.4	2,992.5	1,806.1
Бусад хангамжийн материал	36,580.8	66,598.4	30,017.6
Дүн	221,776.4	252,701.8	30,925.3

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл тайлант оны эцэст өмнөх оны үлдэгдлээс материаллаг хэмжээгээр өсөхөд эм боох материал, хүнсний материал, бусад хангамжийн материалын дансны үлдэгдлүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- Ковид- 19 цар тахалтай холбоотойгоор ЭМТ-д бүртгэлтэй нэг удаагийн тусгай хэрэгсэл болох нүүрний хаалт, хамгаалалтын шил, өмсгөл, ариутгалын бодис, эм боох нөөцийн материалын үлдэгдэл,
- БШУЯ-наас 15,096.9 мянган төгрөгийн сурах бичиг, Теккрафт ХХК-иас 1,300.0 мянган төгрөгийн ариутгалын гэрэл, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 14.528.4 мянган төгрөгийн хурд сааруулагч, зогсоолын тэмдэг, гал сөнөөгчийн хувцас зэрэг хандивын орлогыг бусад хангамжийн материалын дансанд бүртгэсэнтэй холбоотой өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

ЕБС:

- **28,353.5** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.
- **2,537.5** мянган төгрөгийн бараа материалыг дансны ангилал буруу бүртгэсэн.

Цэцэрлэг:

- **21,776.4** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

ИТХ:

- Жолоочийн тооцооны хуудсыг аргачлалын дагуу хөтлөөгүй, шатахуун олгох маршрутад явах км болон 100 км-т зарцуулах жишиг нормыг зөрүүтэй тооцож **2,526.0** мянган төгрөгийн шатахууны зардлын гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй.

ЗДТГ:

- Бараа материалын дансанд 5,971.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 6,807.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийт **12,779.3** мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн.

- Жолоочийн тооцооны хуудсыг аргачлалын дагуу хөтлөөгүй, шатахуун олгох маршрутад явах км болон 100 км-т зарцуулах жишиг нормыг зөрүүтэй тооцож **18.515.5** мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй.
- Ковид-19 цар тахал болон малын шүлхий өвчний үед хяналтын пост ажиллуулсан хугацаанд гарсан хүнсний зардлын 2,636.2 мянган төгрөг, барилгын урсгал засварын 4,425.2 мянган төгрөгийн зэрэг нийт **7,061.4** мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гүйцэтгэж, тайлагнасан.
- Бараа материалын **8,268.9** мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй.

ЭМТ:

- Бараа материалын **5,051.9** мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй.
- Өмч хамгаалах зөвлөлөөр эдэлгээний хугацаа, зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлтийг үндэслэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд **6,676.0** мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг олгосон.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,990,759.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 4,669,819.3 мянган төгрөг болж, 679,059.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	3,812,561.3	3,889,700.7	77,139.4
Хуримтлагдсан элэгдэл	(626,885.4)	(737,262.9)	(110,377.5)
Авто-тээврийн хэрэгсэл	202,629.6	187,205.6	(15,424.0)
Хуримтлагдсан элэгдэл	(149,546.0)	(59,885.5)	89,660.6
Машин тоног төхөөрөмж(компьютер)	364,375.1	441,709.6	77,334.4
Хуримтлагдсан элэгдэл	(237,959.3)	(109,256.4)	128,702.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	98,873.3	145,436.2	46,562.8
Хуримтлагдсан элэгдэл	(55,238.4)	(52,081.5)	3,156.8
Зам, гүүрийн байгууламж	494,163.8	529,187.6	35,023.8
Хуримтлагдсан элэгдэл	(136,481.5)	(193,166.3)	(56,684.8)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	14,000.0	14,000.0	-
Бусад үндсэн хөрөнгө	208,227.4	609,853.0	401,625.6
Хуримтлагдсан элэгдэл	(87,003.6)	(87,968.7)	(965.1)
Ном	18,815.7	22,867.8	4,052.2
Программ хангамж	7,350.0	7,190.0	(160.0)
Хуримтлагдсан элэгдэл	(1,868.8)	(2,456.3)	(587.5)
Бусад биет бус хөрөнгө	64,746.3	64,746.3	-
Дүн	3,990,759.6	4,669,819.3	679,059.7

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн данс нь тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 34,533.8 мянган төгрөг, ХАА-н газраас тариалангийн талбайн хашаа 404,365.2 мянган төгрөг, ОНХС-аас 97,139.4 мянган төгрөг, ЕБС-иас ЗДТГ-т шилжүүлэн өгсөн хуучин дотуур байр 144,528.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 660.0 мянган төгрөг,

элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэн 147,874.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталсан 163,687.1 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ:

- ТӨБЗГ-ын 2021 оны 399 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид шилжүүлсэн 2019 онд ашиглалтад орсон 404,365.2 мянган төгрөгийн тариалангийн талбайн 50км хашааг үндсэн хөрөнгөд бүртгээгүй.
- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийсэн 77,139.4 мянган төгрөгийн нэгдсэн халаалтын өргөтгөлийн ажлыг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн нэгдсэн халаалтын шугам дээр нэмж капиталжуулаагүй.
- Тайлант онд худалдан авсан 1,485.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн .

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,650.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 61,169.1 мянган төгрөг болж, 59,518.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Бүүрсан -
Ажилчидтай холбоотой өглөг	-	3,266.8	3,266.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	49,216.1	49,216.1
Байгууллагад төлөх өглөг	1,650.7	8,686.2	7,035.5
Нийт дүн	1,650.7	61,169.1	59,518.4

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажилчидтай холбогдсон өглөг дансны үлдэгдэл 3,266.8 мянган төгрөг болсон нь ЭМДЕГ-аас ковидын санхүүжилт дутуу орж ирснээс шалтгаалан ажилчдын илүү цагийн хөлсийг олгоогүйтэй холбоотой байна.

Бараа үйлчилгээний зардлын өглөгийн дансны үлдэгдэл 49,216.0 мянган төгрөг болсон нь ЭХЗХ-ны 2019 оны 522 дугаар тогтоолоор цахилгаан дулааны үнэ тарифт өөрчлөлт орсон боловч төсөвт зардлыг нэмэгдүүлээгүйгээс ЭМТ 7,116.9 мянган төгрөг, ЕБС 23,057.0 мянган төгрөг, Соёлын төв 9,470.5 мянган төгрөг, ЗДТГ 8,374.5 мянган төгрөг зэрэг нийт 48,018.9 мянган төгрөгийн халаалтын өр төлбөр үүссэн болон ЭМТ-ийн ковид-19 цар тахлын үед хөнгөн хэлбэрийн гэрээр эмчлэгдэж байгаа иргэдэд олгох эмийн багцыг Монос эмийн сангаас зээлээр худалдан авч бэлтгэсэн 1,197.1 мянган төгрөгийн өр төлбөрүүдээс тус тус шалтгаалсан байна.

Байгууллагад төлөх өглөг дансны үлдэгдэл нь ЭМТ- нь Мандах жаргал ББН-аас бичиг хэргийн материалын 115.5 мянган төгрөг, Монгол фарм ХХК-иас шээсний анализатор, түргэвчилсэн тест худалдан авсан 2,350.3 мянган төгрөг, Медбуян

ХХК-иас 4,570.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж болон 2017 онд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй 1,650.7 мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлж, буцаан олгохоор үүсгэсэн зэрэг өр төлбөрүүдээс шалтгаалан өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

ЭМТ:

- НДШ-ийн 696.9 мянган төгрөг, ХХОАТ-ын 267.0 мянган төгрөгийн өр төлбөрийг цалингийн тооцооны өглөгөөс байгууллагад төлөх өглөгөөр бус ажилчидтай холбоотой өглөгөөр бүртгэсэн,

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,495,101.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,685,528.0 мянган төгрөг болж, 1,190,426.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	906,101.3	906,101.3	(0.00)
Хуримтлагдсан үр дүн	2,940,651.1	4,131,077.5	1,190,426.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	648,349.2	648,349.2	-
Дүн	4,495,101.6	5,685,528.0	1,190,426.4

Эх сурвалж: Орхон сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,685,528.0 мянган төгрөг болж 1,190,426.4 мянган төгрөгөөр өссөн нь УТХО-аар 404,592.7 мянган төгрөгийн тариалангийн талбайн хашаа хүлээн авсантай холбоотойгоор тайлант оны хуримтлагдсан үр дүн өсөхөд голлон нөлөөлсөн байна.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон байрны түрээсийн төлбөр 1,440.0 мянган төгрөг, Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг төрөөс даасантай холбоотойгоор Гавшгай ус ААТҮГ-аас 12,326.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, сумын байгаль орчны улсын байцаагчийн тогтоосон торгуулийн актыг шүүхээс албадан төлүүлэх шийдвэр гаргасны дагуу Сайхан сум дахь ШШГ хэлтсээс төвлөрүүлсэн 5,170.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамжийн орлого 154.0 мянган төгрөг, өвсний фондоос өвс борлуулсны орлого 1,320.0 мянган төгрөг, оношлуурын төлбөрийн орлого 3,069.0 мянган төгрөг, өмнөх оны татан төвлөрүүлэлтээс ЗДТГ-т 1,549.1 мянган төгрөг, ЭМТ-д 4,183.8 мянган төгрөг, ЭМТ-ийн эмийн сангийн орлогоос 40,839.4 мянган төгрөг, нийт 70,051.3 мянган төгрөгийн орлого /мөнгөн гүйлгээний

тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлого ангилалд тайлагнагдсан/ төвлөрүүлсэн байна.

Орлогын данстай холбоотой **5,170.0** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ: Сумын төсвийн татварын бус орлогод төвлөрөх 5,170.0 мянган төгрөгийн торгуулийн орлогыг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого авч зарцуулсан.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **31,698.5** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

ИТХ:

- ИТХ-ын нарийн бичгийн дарга Н.Алтаншагайд 250.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон.

ЗДТГ:

- Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байхад ЗДТГ-ын дарга Ш.Ганчимэгт 209.1 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.
- Авто тээврийн хэрэгслийн албан татварын 2015-2019 онуудын хооронд үүссэн 2,497.3 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тайлант жилийн зардлаар бүртгэсэн. / өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгээгүй /
- Албан томилолтын тооцооны хуудсанд гүйцэтгэх ажлын чиг үүрэг, хийсэн ажлыг тайлагнаагүй, ирсэн, явсан хугацааг бичээгүй, хаалгасан албан тушаалтны гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй 644.0 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан.
- Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, төсвийн тооцоо судалгаа хийлгүйгээр ЗДНХ-өөс 15,901.0 мянган төгрөгийн зардал гаргасан.

Соёлын төв:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг 2 албан хаагчид 2,646.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.
- Ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэлгүйгээр төрийн үйлчилгээний албан хаагчдад үр чадварын нэмэгдэл олгосон.

ЕБС:

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 3,778.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Цэцэрлэг:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд тухайн оны төсвийн батлагдсан төлөвлөгөөг 5,273.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан.

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүн 498.9 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн.

ЭМТ:

- Ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэлгүйгээр төрийн үйлчилгээний албан хаагчдад үр чадварын нэмэгдэл олгосон.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Орхон сумын ИТХ-ын “2021 оны төсөвт өөрчлөлт оруулан батлах тухай” 2021 оны 21 дүгээр тогтоолоор 133,501.2 мянган төгрөгийн татварын орлого, 20,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 591,383.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 3.8 дахин давж биелсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	20,000.0	18,566.4	(1,433.6)	92.8
2	Эрхийн шимтгэлийн орлого	300.0	9,089.2	8,789.2	30.3 дахин
3	Хөрөнгө борлуулсны орлого	1,390.0	6,892.2	5,502.2	495.8
4	Бууны албан татвар	1,920.0	1,426.0	(494.0)	74.3
5	Малд ногдуулах албан татвар	70,000.0	91,396.5	21,396.5	130.6
6	Улсын тэмдэгтийн хураамж	6,000.0	4,916.8	(1,083.2)	81.9
7	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000.0	451.5	(548.5)	45.2
8	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,000.0	1,333.2	(2,666.8)	33.3
9	Газрын төлбөр	13,083.0	28,557.2	15,474.2	218.3
10	Дуудлага худалдаа	-	38.8	-	-
11	Ойн нөөц ашигласны төлбөр	-	64.5	-	-
12	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	100.0	90.0	(10.0)	90.0
13	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	15,707.7	23,918.0	8,210.3	152.3
14	Торгуулийн орлого	16,500.0	401,599.1	385,099.1	24.3 дахин
15	Бусад орлого	3,000.0	2,563.6	(436.4)	85.5
16	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.0	480.0	(20.0)	96.0
	Нийт дүн	153,500.7	591,383.0	437,402.8	3.8 дахин

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд эрхийн шимтгэлийн орлого 8,789.2 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 5,502.2 мянган төгрөг, малд ногдуулах албан татвар 21,396.5 мянган төгрөг, газрын төлбөр 15,474.2 мянган

төгрөг, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 8,210.3 мянган төгрөг, торгуулийн орлого 385,099.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн бол үйл ажиллагааны орлого 1,433.6 мянган төгрөг, бууны орлого 494.0 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 1,083.2 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 548.5 мянган төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.666,8 мянган төгрөг, бусад орлого 436.4 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Хөрөнгө борлуулсны орлого:** нь Иргэний үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогоос шалтгаалан давж биелсэн.
- **Малд ногдуулах албан татварын орлого:** Малын тоо толгойн албан татварын хуулийн мэдээллийг мал бүхий иргэдэд сайн хүргэж хэрэгжилтийг хангаснаар орлого давсан.
- **Газрын төлбөр:** Газрын албаны мэргэжилтэн болон татварын байцаагч нар хамтран ажиллаж хуримтлагдсан өр төлбөрийг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас барагдуулсан болон газар эзэмших, эрх шилжүүлсэн төлбөрийн орлогоос шалтгаалсан.
- **Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого:** Иргэн, ААНБ-дад бизнесийн зорилгоор хадлан бэлтгэх бэлчээрийн талбай ашигласны төлбөрийн орлогоос шалтгаалсан байна.
- **Торгуулийн орлого:** Хөтөл цемент шохой ХК нь Орхон сумын нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй талбайгаас байгалийн шохой бэлтгэсэн 327,663.6 мянган төгрөгийн торгуулийн орлогыг Сайхан сум дах сум дундын ШШГ хэлтсээс барагдуулсан болон Цагдаагийн хэлтсийн хяналтын постын торгуулийн орлогоос тус тус шалтгаалан давж биелсэн байна.

Тасарсан орлогууд:

- **Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого:** ЗГ-ын 211-р тогтоолоор чөлөөлөгдсөн хогны хураамжийн төлбөр 2,3,6-р саруудын санхүүжилт олгогдож 7-н сарын орлого дутуу төвлөрсөн.
- **Улсын тэмдэгтийн хураамжийн орлого:** Ковид-19 цар тахлын улмаас арилжааны банкууд иргэдийн холбогдох бичиг баримт, зээлийн гэрээг нотариатаар батлуулахыг шаардахгүйгээр үйлчилгээ үзүүлдэг болсон, иргэний үнэмлэх, шилжилт хөдөлгөөний хураамжууд төвлөрөөгүй зэргээс шалтгаалсан байна.
- **Бусад орлого:** Дулаан ханган нийлүүлэгч Эл Си Би ХХК, сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга нарын байгуулсан гуравласан гэрээний 5.11 дэх заалтын дагуу төсөвт байгууллагуудаас төлсөн дулааны төлбөрийн 3 хувийг сумын төсөвт төвлөрүүлдэг бөгөөд энэ онд өр төлбөр үүссэн тул уг 3 хувийг төвлөрүүлж чадаагүй,
- **Ан амьтны нөөц ашигласны төлбөр:** Орхон голын загас багассан, худалдан авалт буурсан нь орлогын төлөвлөгөөнд нөлөөлсөн байна.

- **Үйл ажиллагааны орлого:** Хувь хүнээс суутгах орлогын албан татварын 10 хувийг хувь хүн өөрөө суутган, тайлангаа илгээх болсонтой холбогдуулан орлого буурсан байна.
- **Бууны орлого:** Галт зэвсэг хэрэглэгчид багассаны улмаас орлого буурсан байна.
- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр:** Төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөөгүйгээс шалтгаалсан.
- **Төсөвт байгууллагын өөрийн орлого:** Цар тахалтай холбоотой үйл ажиллагаа зогсонги байдалд орсонтой холбоотой орлого багассан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,140,156.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,140,156.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 137,883.0 мянган төгрөг, эхний үлдэгдлээс санхүүжих 4,000.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 650,150.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 97,139.4 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 1,137,044.3 мянган төгрөг, ЭМДС-аас санхүүжилтийг 24,025.5 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 89,914.6 мянган төгрөг, нийт 2,140,156.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор аймгийн 2021 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2021 оны 21 дугаар тогтоолыг үндэслэн сумын төсөвт дараах өөрчлөлт оруулан, төсвийн орлого, зарлагыг тус бүр 20,617.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,160,774.5 мянган төгрөг болгон өөрчилж баталсан байна. Үүнд:

- Сумын татварын орлогын төлөвлөгөөнөөс давсан 15,617.7 мянган төгрөгөөр сумын төсвийн орлогыг нэмэгдүүлж, тодотгосон.
- Аймгаас олгох санхүүгийн дэмжлэгээр нэмэгдүүлсэн 5,000.0 мянган төгрөгийг болон татварын орлогын 15,617.7 мянган төгрөгийн орлогоос Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан ЗДТГ-ын нөөц хөрөнгийн зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр, ИТХ-ын цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 3,685.4 мянган төгрөг, ЗДТГ үндсэн үйл ажиллагааны зардлыг 6,408.7 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага болох Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг 5,523.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн зэргээс шалтгаалан төсвийн зардлыг нийт 20,617.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 2,160,774.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас аймгийн Засаг даргын 2021 оны А/372 дугаар захирамжаар ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж тус сумын ТЗШ-ийн байгууллагуудаас нийт 6,910.8 мянган төгрөгийг хасаж 1,130,133.5 мянган төгрөг болгоснааошалтгаалж **2,153,863.7** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

Тайлант оны нийт төсвөөс 1,907,558.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 157,139.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 89,165.6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 655,150.0 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 153,500.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМДС-аас 24,025.5 мянган төгрөгийг, 97,139.4 мянган төгрөгийг ОНХС-аас, 1,130,133.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 89,914.6 мянган төгрөгийг СХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, урьд оны үлдэгдлээс 4,000.0 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 655,150.0 мянган төгрөг, ОНХС-аас 97,139.4 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1,076,354.2 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 10,336.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 70,482.7 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 89,733.4 мянган төгрөг, нийт 1,999,196.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,999,196.0 мянган төгрөг буюу 92.8 хувьтай тайлагнагдсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 61,321.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,523.9 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 2,785.5 мянган төгрөгөөр, нормативт зардал 14,514.4 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 1,447.5 мянган төгрөгөөр, томилолтын зардал 588.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 8,907.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 5,310.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 2,102.1 хөрөнгийн зардал 52,000.0 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээл 165.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 төсөл арга хэмжээнд 60,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 2 төсөл, арга хэмжээнд 97,139.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын 1 төсөл арга хэмжээнд 8,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн 2 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж 97,139.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Дээд шатны төсвийн захирагчдаас 106,823.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 70,051.3 мянган төгрөг, иргэн хуулийн этгээдээс ковид-19 цар тахалтай тэмцэхэд өгсөн хандив 14,509.5 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 5,128.5 мянган төгрөг, нийт 196,513.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-т аймгийн ЗДНХ-өөс шүлхий өвчинтэй холбоотой зардалд 5,128.5 мянган төгрөг,
- Мал эмнэлгийн газраас малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,000.0 мянган төгрөг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас кейс үйлчилгээний төлбөр 2,400.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн малын тооллогын зардалд 537.0 мянган төгрөг, аж ахуй нэгж байгууллагын тооллогын зардал 309.5 мянган төгрөг, аймгийн ХХААГ-аас мал сүрэгт үзлэг ангилалт хийхэд 277.7 мянган төгрөг, ургац хураалтын дүн мэдээ нэгтгэлийн шатахууны зардалд 200.0 мянган төгрөг, аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаас зам, завсар тэмдэг, тэмдэглэгээ хийхэд 32,223.8 мянган төгрөг, сумын ИТХ-д аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 300.0 мянган төгрөг, сумын ЭМТ-д аймгийн ЭМГ-аас цар тахлын үед томилолтоор / Алтанбулаг, Сайхан Жавхлант сум /ажилласан албан хаагчдын илүү цагийн хөлс 12,977.9 мянган төгрөг, ЭМДЕГ-аас ковидын санхүүжилт 24,092.8 мянган төгрөг, вакцины санхүүжилт 17,715.0 мянган төгрөг, гэрийн хяналтын санхүүжилт 9,875.2 мянган төгрөг, Цэцэрлэгт аймгийн БСУГ-аас халдваргүйжүүлэлтийн зардалд 128.0 мянган төгрөг, ЕБС-д боловсролын чанарын шинэчлэлийн төслийн санхүүжилтэд 4,300.0 мянган төгрөг, ариутгалд 343.0 мянган төгрөг, үнэлгээний шалгалтын бичиг хэрэг зардал 144.0 мянган төгрөг зэрэг нийт 106,823.9 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн,
- ЗДТГ нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор буюу сумын төрийн банкнаас байрны түрээсийн төлбөрт 1,440.0 мянган төгрөг, Гавшгай ус ААТҮГ-аас айл өрхийн цэвэр усны зардал 12,326.0 мянган төгрөг, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь ШШГ хэлтсээс 5,170.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамжийн орлого 154.0 мянган төгрөг, өвсний фондоос борлуулсны орлого 1,320.0 мянган төгрөг, оношлуурын төлбөрийн орлого 3,069.0 мянган төгрөг, өмнөх оны татан төвлөрүүлэлтээс ЗДТГ-т 1,549.1 мянган төгрөг, ЭМТ-д 4,183.8 мянган төгрөг, ЭМТ-ийн эмийн сангийн орлогоос 40,839.4 мянган төгрөг нийт 70,051.3 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.
- Иргэн, хуулийн этгээдээс ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулан ЗДТГ-т хандивласан 1,335.0 мянган төгрөг, ЭМТ-д 13,174.5 мянган төгрөг нийт 14,509.5 мянган төгрөгийн хандив тусламжийн орлого төвлөрсөн байна.

Үүнээс цалингийн зардалд 25,936.6 мянган төгрөг, НДШ-ийн зардалд 3,285.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,490.9 мянган

төгрөг, хангамж бараа материалын зардалд 8,556.3 мянган төгрөг, нормативт зардалд 67,257.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 5,781.0 мянган төгрөг, томилолтын зардалд 180.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 15,033.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 33,298.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 23,800.0 мянган төгрөг, мянган төгрөгийг зарцуулж 11,893.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Орхон сумын ЭМТ-ийн бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал зэрэглэлийг ЭМТ-ийн даргын 2021 оны Б/01 дугаар тушаалаар батлахдаа Эрүүл мэндийг хамгаалах технологи, сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны /MNS 5081:2013/ стандартыг баримталж боловсруулаагүйгээс батлагдсан орон тоонд байхгүй архив албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан, ариутгагч, дархлаажуулалтын сувилагч гэсэн орон тоог хавсран ажиллуулах тушаал гарган нэмэгдэл цалин хөлс олгосон байна.

Энэ нь Эрүүл мэндийг хамгаалах технологи, сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны /MNS 5081:2013/ стандартад заасан зэрэглэлд хамаарах сумын хүн амын тооны харьцаанд нийцүүлээгүйгээс эмнэлгийн ажилтнуудыг ачааллыг нэмэгдүүлэх, боловсон хүчний дутагдалд орох, ажлын үр дүн буурах эрсдэлийг үүсгэж байна. Цаашид байгууллагын бүтэц, орон тоо албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн боловсруулан мөрдөх нь зүйтэй юм.

3.7.3 Сумын ИТХ-ын Тэргүүлэгч, төлөөлөгчдийн зохион байгуулсан ажил үйл ажиллагааны үр дүнг тооцохгүйгээр улирал бүр 2,520.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг 21 төлөөлөгчид олгож байгаа нь сумын ИТХТ-ийн 2021 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Сумын ИТХ-ын Тэргүүлэгч, Төлөөлөгчдөд олгох урамшууллын шалгуур үзүүлэлтийг батлах тухай” журмын хэрэгжилтийг хангаагүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, журмын хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэлийг үүсгэж байгаа учир цаашид анхаарч ажиллах нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт: 8 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Засаг дарга	155	103	50	2
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	81	56	14
3	Засаг даргын Тамгын газар	151	92	57	2
4	Эрүүл мэндийн төв	151	136	15	0
5	Соёлын төв	151	88	60	3
	Нийт дүн	759	500	238	21

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 759 мэдээллээс 500 мэдээллийг хугацаанд нь, 238 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол огт мэдээлээгүй 21 мэдээлэл байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 66,564.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 65,071.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.2 хувиар хэмнэсэн,
- Соёлын төвийн тайлант оны үйл ажиллагаанд 136,017.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 133,950.0 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.5 хувиар хэмнэсэн,

Эдгээр нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 586.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,683.4 мянган төгрөгийн

зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 104,409.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт: 9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	586.8	1	586.8			100
Албан шаардлага	4	4,683.4	4	4,683.4			100
Зөвлөмж	4	104,409.7	3	83,527.8	1	-	70.0
Нийт	9	109,679.9	8	88,798.0	1		88.9

ИТХ, ЗДТГ, Соёлын төв нь өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

3.11.2 Өмнөх оны богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд бүртгэлтэй ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны 1,650.7 мянган төгрөгийн үлдэгдлийг 2017 онд татан төвлөрүүлж, буцаан олгохоор өр төлбөр үүсгэсэн боловч 2021 он дуустал барагдуулаагүй байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар дараагийн аудитаар дахин шалгах нь зүйтэй юм.

3.11.3 ОНХС-ийн 2020 оны хөрөнгө оруулалтаар Чамин хаус ХХК нь 29,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хогны машин нийлүүлэх тендерт шалгарсан байна. Гэвч тухайн үед ковид-19 цар тахлаас шалтгаалан хөдөлгөөний хязгаарлалт хийснээс бэлтгэн нийлүүлэх боломжгүй гэх үндэслэлээр хогны машин худалдан авах №2020ОР/ХАР/-08 дугаартай гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн шилжүүлж ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэсэн боловч бэлтгэн нийлүүлэгч талаас одоог хүртэл тухайн тээврийн хэрэгслийг нийлүүлээгүй байна.

Сумын Засаг дарга Г.Бат-Орхон нь Чамин-Хаус ХХК-ийг энэхүү нөхцөл байдлын улмаас 2021 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн 1/408 дугаартай албан бичгээр Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст шалгуулж асуудлыг шийдвэрлүүлэх гомдлыг гаргасан боловч тайлант онд шийдвэрлэгдээгүй байгаа тул дараагийн аудитаар дахин шалгах нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 6 төсвийн байгууллага, орон нутгийн төсөл, сангийн 2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Орхон сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 651,531.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 511,416.1 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 3,105.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 9,456.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 127,553.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 589,312.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 499,327.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 3,105.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 9,456.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 77,424.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

ЗДТГ:

- ✓ Хэрэгжээгүй ажлын санхүүжилт / буцааж авах / 9,641.1 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн боловч санхүүжилтийн авлагаар бүртгээгүй,
- ✓ ТӨБЗГ-ын 2021 оны 399 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид шилжүүлсэн 2019 онд ашиглалтад орсон 404,365.2 мянган төгрөгийн тариалангийн талбайн 50км хашааг үндсэн хөрөнгөд бүртгээгүй,
- ✓ ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийсэн 77,139.4 мянган төгрөгийн нэгдсэн халаалтын өргөтгөлийн ажлыг үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа нэгдсэн халаалтын шугам дээр нэмж капиталжуулаагүй,
- ✓ Тайлант онд худалдан авсан 1,485.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нийт 492,630.7 мянган төгрөгийн алдааг залруулав.

ЭМТ:

- ✓ НДШ-ийн 696.9 мянган төгрөг, ХХОАТ-ын 267.0 мянган төгрөгийн өр төлбөрийг цалингийн тооцооны өглөгөөс байгууллагад төлөх өглөгөөр бус ажилчидтай холбоотой өглөгөөр бүртгэсэн,

ТТЗ:

- ✓ Санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ-ын 1,549.1 мянган төгрөг, ЭМТ-ийн 4,183.8 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын тооцооны өмнөх оны устгах бичилтийг хийгээгүй, зэрэг нийт 499,327.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 ЗДТГ: Сахилгын шийтгэл ногдуулсан ЗДТГ-ын дарга Ш.Ганчимэгт сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 209.1 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6 дахь “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 2.7 дэх “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээлгэсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй албан хаагчид олгосон үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2.2 Соёлын төв: Тайлант онд эрхлэгч Б.Амартуяад 1,111.8 мянган төгрөг, соёлын ажилтан М.Наранчимэгт 1,534.2 мянган төгрөг, нийт 2,646.0 мянган төгрөгийн ээлжийн амралт, нэмэгдэл цалин урамшууллыг илүү тооцож олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.2.3 ЗГХЭГ, Удирдлагын академи, БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтийн хамтарсан “Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх” чиглэлийн хүрээнд 4 өдрийн сургалтыг зохион байгуулж, албан томилолтын зардлыг тооцож олгосон атал сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Н.Алтаншагайд 250.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон 250.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

4.3.1 Сумын төсвийн орлогод төвлөрүүлбэл зохих 5,170.0 мянган төгрөгийн торгуулийн орлогыг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9 дэх “Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ. 23.9.2: Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, **хүү, торгуулийн орлого**” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

4.3.2 Өмнөх онуудын санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй авто тээврийн хэрэгслийн албан татварын 2015-2019 онуудын хооронд үүссэн 2,497.3 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлант жилийн батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар бүртгэж, тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.3: Бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах...**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.3.3 ЭМТ нь эмийн сангаас хувь хүмүүст зээлээр борлуулалт хийсэн боловч төлбөрийг барагдуулаагүйгээс 1,789.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах**” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх

4.3.4 ЗДТГ-нь анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 42,121.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, 12,779.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, хөрөнгө болон авлагын үлдэгдлийг бүртгэл тайланд дутуу тусгасан зэргээр нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, эрхийн актын дагуу хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага

дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.1: “ Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт “, 13 дугаар зүйлийн 13.4 дэх “ ...байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөл бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх “ Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Ангилал”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДТГ-ын нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт **67,644.7** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ЗДТГ 18.515.5 мянган төгрөг, ИТХ 2,526.0 мянган төгрөг зэрэг нийт **21,041.5** мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй, жолоочийн тооцооны хуудсыг аргачлалын дагуу хөтлөөгүй, шатахуун олгох маршрутад явах км болон 100 км-т зарцуулах жишиг нормыг зөрүүтэй тооцсон.
- ЗДТГ нь ковид-19 цар тахал болон малын шүлхий өвчний үед хяналтын пост ажиллуулсан хугацаанд гарсан хүнсний зардлын 2,636.2 мянган төгрөг, барилгын урсгал засварын 4,425.2 мянган төгрөгийн зэрэг нийт **7,061.4** мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гүйцэтгэж, тайлагнасан.
- ЗДТГ нь албан томилолтын тооцооны хуудсанд гүйцэтгэх ажлын чиг үүрэг, хийсэн ажлыг тайлагнаагүй, ирсэн, явсан хугацааг бичээгүй, хаалгасан албан тушаалтны гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй 644.0 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан.
- Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, төсвийн тооцоо судалгаа хийлгүйгээр ЗДНХ-өөс 15,901.0 мянган төгрөгийн зардал гаргасан.

- Тайлант онд ЗДТГ 8,268.9 мянган төгрөг, ЭМТ 5,051.9 мянган төгрөг нийт **13,320.8** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.
- **ЭМТ:** Өмч хамгаалах зөвлөлөөр эдэлгээний хугацаа, зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлтийг үндэслэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд **6,676.0** мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг олгосон,

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

2. Нэмэгдэл цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЭМТ болон Соёлын төвийн төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын... албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ... тооцож, сар бүр олгоно" гэж заасныг зөрчсөн ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдлийг сар бүр олгож байх.

3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ-ын бараа материалын дансанд 5,971.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 6,807.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт **12,779.3** мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн байгаа нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 13 (б)-д "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэж тодорхойлсон заалттай нийцээгүй бөгөөд "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийг 2022 оны эхний хагас жилд багтаан бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэж, залруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Хариуцл ага тооцуула х		Албан шаардлага		Зөвлөмж			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал																	
1	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	Санхүүгийн нэгтгэсэн тайланд ЗДТГ 1,549.1 мянган төгрөг, ЭМТ-ийн 4,183.8 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын тооцооны өмнөх оны устгах бичилтийг хийгээгүй.	1	5,732.9	1	5,732.9										
13	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлж буцаан авах хэрэгжээгүй ажлын санхүүжилтийн тооцоог татаас санхүүжилтийн авлагаар бүртгээгүй	1	9,641.1	1	9,641.1										
14	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь ТӨБЗГ-ын 2021 оны 399 дугаар тогтоолоор орон нутгийн өмчид шилжүүлсэн 2019 онд ашиглалтад орсон тариалангийн талбайн 50км хашааг үндсэн хөрөнгөд бүртгээгүй	1	404,365.2	1	404,365.2										
15	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийсэн нэгдсэн халаалтын өргөтгөлийн ажлыг үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа нэгдсэн халаалтын шугам дээр нэмж капиталжуулаагүй,	1	77,139.4	1	77,139.4										
16	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь Тайлант онд худалдан авсан үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	1,485.0	1	1,485.0										

21	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЭМТ нь НДШ-ийн 696.9 мянган төгрөг, ХХОАТ-ын 267.0 мянган төгрөгийн өр төлбөрийг цалингийн тооцооны өглөгөөс байгууллагад төлөх өглөгөөр бүртгээгүй ажилчидтай холбоотой өглөгөөр бүртгэсэн	1	963.9	1	963.9													
2	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЗДТГ-ын нягтлан бодогч нь хууль тогтоомжоор хүлээсэн болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн.	1	-				1											
4	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Н.Алтаншагайд албан томилолтын зардлыг давхардуулан олгосон	1	250.0		250.0	1	250.0											
5	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй байгаа ЗДТГ-ын дарга Ш.Ганчимэгт урамшуулал цалин олгосон	1	209.1		209.1	1	209.1											
5	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	Соёлын төвийн 2 албан хаагчид цалин ,урамшуулал давхардуулан илүү тооцож олгосон	1	2,646.0		2,646.0	1	2,646.0											
6	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь Авто тээврийн хэрэгслийн албан татварын 2015-2019 онуудын хооронд үүсэн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй, тайлант жилийн зардлаар бүртгэсэн	1	2,497.3		2,497.3				1									2,497.3
17	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЭМТ нь эмийн сангаас хувь хүмүүст эзлээр борлуулалт хийж барагдуулаагүй авлага үүсгэсэн	1	1,789.0		1,789.0				1									1,789.0
	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	Сумын төсвийн татварын бус орлогод төвлөрөх торгуулийн орлогыг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого авч зарцуулсан.	1	5,170.0		5,170.0				1									5,170.0

Сэлэнгэ аймгийн Орхон сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан	1	64,644.7															1	64,644.7
7	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЗДТГ нь бараа материалын дансанд тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг бүртгэсэн	1	12,779.3															1	12,779.3
18	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЭМТ болон Соёлын төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэлгүйгээр олгосон	1	-															1	
Дүн				16	589,312.9	6	499,327.5	3	3,105.1	1	3	9,456.3	3	77,424.0							
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																					
1	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчиж батлагдсан төсвийг 10-аас доош хувиар хэмнээгүй.	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	ТТЗ	СЭА-2022/08-НА-СТА-ТТЗ	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1																	
Дүн				2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн				18	589,312.9	6	499,327.5	3	3,105.1	1	5	9,456.3	3	77,424.0							